

Гайхалтай багш нарын үлгэр Жишээ

ЕРӨНХИЙЛӨГЧ ТОМАС С. МОНСОН

Тэргүүн Зөвлөл Нэгдүгээр Зөвлөл



Сайн заах олон элемент, зарчмуудын талаар Сүмийн агуу багш нар бидэнд гайхалтай зөвлөгөө өгөхийг бид сая сонслоо.

Өмнө дурдагдсанчлан, бид бүгдээрээ багш нар бөгөөд өөрт байгаа бүхнээ үүндээ зориулах үүрэгтэй билээ.

Миний амьдралд нөлөөлж, маш чухал, хэзээ ч мартагдахааргүй хичээлүүдийг надад заасан хэдэн хүний талаар би хуваалцмаар байна.

Хүн бүхэнд түүх бий

Семинар институт, ер нь Сүмд хамгийн сайн заадаг байсан чөлөөнд гарсан Ерөнхий Эрх мэдэлтэн, Ахлагч Марион Д.Хэнксийн

талаар би бодож байна. Тэр заах маш олон арга барилыг эзэмшсэн хүн байсан юм.

Нэг удаа Ахлагч Хэнкс нэгэн номлолын бүсэд очин, тухайн номлолд үйлчилж байгаа номлогч бүртэй ярилцлага хийсэн юм. Би зэргэлдээх бүсэд нь томилогдсон байсан бөгөөд Ахлагч Хэнкс болон тухайн номлолын ерөнхийлөгчтэй хамт онгоцны буудал уруу явсан юм.

Номлогч бүртэй уулзаж тэдэнтэй ярилцсан нь ямар агуу боломж байсныг Ахлагч Хэнкс номлолын ерөнхийлөгчид хэлэв. Нэг эгчээс тэр “номлолынхоо тухай яриач. Номлогч эгч болон дуудагдсандаа чи ямар сэтгэгдэлтэй байна вэ” гэж асуухаар өдөөгдсөн гэдгээ тэр ярьсан юм.

Өөрийнх нь даруухан эцэг, фермер Их Эзэн хийгээд түүний хаант улсын төлөө маш их зүйлээ золиосолсон гэдгийг тэрээр түүнд хэлжээ. Номлогч болох далд хүслийнх нь талаар охинтойгоо ярих үедээ тэрээр номлолд хоёрын хоёр хүүгээ явуулчихсан байжээ. Охиндоо туслахад нь түүнийг бэлтгэхийн тулд Их Эзэн түүнд хэрхэн тусалсан талаар тэр мөн тайлбарласан байна. Мөнгөний барьцаанд өгөх ямар ч эд материал өөрт нь байхгүй гэдгийг Их Эзэнтэй ярилцахаар тэрээр талбайдаа очжээ.

Охиноо номлолд явуулахын тулд яаж тусалж чадахыгаа тэрээр мэдэхийг хүсчээ. Сонгино тарь гэсэн илчлэлт түүнд ирсэн байна. Тэрээр буруу ойлголоо гэж боджээ. Ийм цаг агаартай газар сонгино ургахгүй, бусад хүмүүс сонгино тарьдаггүй, өөрт нь сонгино тарих ямар ч туршлага байхгүй ш дээ гэж тэр боджээ.

Хэсэг хугацаанд Их Эзэнээс зөрсний эцэст түүнд сонгино тарь гэсэн илчлэлт дахин иржээ. Тэгээд тэрээр мөнгө зээлж, үр худалдан аваад сонгино тарин, арчилж мөн залбирчээ. Цаг агаар сайжирч, сонгино сайн ургажээ. Тэрээр сонгиноо худалдаж, банкинд, засгийн газарт, мөн Их Эзэнд тавьсан өрөө даржээ. Мөн үлдсэн мөнгөө охиныхоо нэр дээр данс нээн хадгалсан бөгөөд энэ нь түүний номлолд хангалтай хүрэхээр байжээ.

Эцэст нь, “Хэнкс ах аа, миний хэрэгцээг мэддэг, хэрэв би хангалттай даруу байх юм бол өөрийнхөө мэргэн ухаанаар надад тусалдаг хайрт Тэнгэрлэг Эцэгтэй итгэхгүй байх ямар ч шалтаг надад байхгүй” хэмээн нулимс дуслуулан хэлсэн тэр

Ерөнхийлөгч Монсоны туршлагаудыг уншиж байхад тань заах болон сурах талаар ямар сэтгэгдэл танд төрж байна вэ? Суралцагч болон багшийн хувьд эдгээр түүхүүдтэй адил төстэй ямар туршлага танд бий вэ?

Ерөнхийлөгч Монсоны туршлага Аврагчийн заах чадваруудыг хэрхэн дүрсэлж байна вэ? Аврагчийн үлгэр жишээг дагахын тулд юу хийж болох талаараа тунгаан бодож залбир.





КРИСТИНА СМИГИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Бидний үдэшлэгийн хуримтлалыг хийсэн тэр цагаан дугтуйг гашуудан шаналсан тэрхүү эцэгт өгсөн багшийн минь өгөөмөр гар.

номлогчийн дуу хоолой, надад төрсөн тэрхүү мэдрэмж, мөн түүний ярьсан энэ түүхийг би хэзээ ч мартахгүй”, хэмээн Ахлагч Хэнкс номлолын ерөнхийлөгчид хэлсэн юм.

Ахлагч Хэнкс хамгийн чухал хичээлийг заасан юм: анги болгон дахь хүүхэд бүрд, Залуу Эрэгтэй эсвэл Залуу Эмэгтэй бүрд, Семинар мөн Институтэд сууж байгаа оюутан бүрд, Ням гарагийн хичээлд сууж байгаа насанд хүрэгч бүрд, номлогч бүрд — тийм ээ, бидний хүн нэг бүрд яригдахаар хүлээгдэж буй түүх гэж бий. Зааж байхад мөн сурч байхад хамгийн их хэрэгтэй элемент бол сонсох юм.

“Өгөх нь авахаас илүү адислагдсан байх болно.”

Жаахан хөвгүүн байхдаа, хүүхэд биднийг хайрлаж мөн сонсдог маш шаргуу, бурханлигаар нөлөөлөгдсөн багшаар заалгах завшаан надад олдсон юм. Түүнийг Люси Гертч гэдэг байв. Ням гарагийн хичээл дээр тэр бидэнд дэлхийн үүсэл, Адамын уналт, Есүсийн цагаатгагч золиослолын талаар заадаг байсан сан. Тэрээр ангиддаа Мосе, Иошуа,

Петр, Томас, Паул, бүр Христ гэсэн хүндтэй зочдыг урин авчирдаг байсан юм. Хэдийгээр бид тэднийг хардаггүй байсан ч, тэднийг хайрлаж, хүндэтгэж, дагаж сурсан.

Ангийн маань нэг хүүхдийн ээж нас барсан гэдгийг багш маань гунигтайгаар зарласан тэр нэг Ням гарагийн өглөөний хичээл шиг сэтгэлд шингэж, зүрхэнд хүрсэн хичээл байгаагүй юм. Тэр өглөө Библи хичээлд ирээгүй бөгөөд яагаад ирээгүй болохыг нь бид мэдээгүй байлаа.

Хичээл “Бусдад өгөх нь бусдаас авахаас илүүтэй адислалыг бидэнд авчирдаг” (Үйлс 20:35) гэсэн сэдэвтэй байлаа. Хичээл дундаа орох үед багш маань номоо хаагаад бидний нүд, чих, зүрх сэтгэлийг Бурханы алдар суу уруу чиглүүлсэн юм. Тэрээр, “Манай ангийн үдэшлэгийн санд хэдэн төгрөг байгаа вэ?” гэж асуув.

“Дөрвөн доллар далан таван цент” хэмээх хариулт эдийн засгийн уналтын тэр өдрийг дэврээв.

Тэгтэл тэрээр маш найрсагаар: “Биллигийн гэр бүл маш их уй гашууг амсаж байгаа. Өнөө өглөө түүний гэрт очиж, гэр бүлийнх нь гишүүдтэй уулзан, өөрсдийнхөө

хуримтлуулсан мөнгийг өгвөл ямар вэ?” хэмээн асуув.

Хэдэн бяцхан хүүхэд гурван гудам алхан Биллигийн гэр орж, түүнтэй бас түүний ах эгч, аавтай мэдэлж байснаа би хэзээ ч мартдаггүй юм. Мэдээж түүний ээж байхгүй байлаа. Бидний цуглуулсан мөнгө хийсэн цагаан дугтуйг багш маань уй гашууд автсан эцэгийн гар дээр тавих тэр үед бид бүгд нүдэндээ нулимастай зогсож байсныг би үргэлж дурсан боддог юм.

Бид чимээгүйхэн тэднийхээс гарч цуглааны байрны зүг буцан алхацгаав. Бидний нүд урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр гялалзаж байлаа; бид илүү их баяр хөөртэй болсон байв; бидний ойлголт улам тэлсэн юм. Бурханы илчлэлтийг хүлээн авсан багш маань бурханлиг үнэний мөнхийн хичээлийг охид хөвгүүддээ заасан нь тэр байлаа. “Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй.”

Тэгэхээр одоо бүгдээрээ Еммау уруу явж байсан шавь нарын үгийг жаахан өөрчлөөд үзье: “Тэрээр судрууд дахь гайхамшгуудыг нээхэд бидний зүрх маань бидний дотор шатаж байсан бус уу?” (Лук 24:32).

Люси Гертч сурагчдаа нэг бүрчлэн мэддэг байсан юм. Тэрээр Ням гарагт ирээгүй хүүхэд бүрийг мэддэг

байсан юм. Тэрээр бидний төлөө санаа тавьдгийг нь бид мэддэг байсан юм. Бидний хэн маань ч түүнийг болон түүний заасан хичээлийг хэзээ ч мартахагүй байх болно.

Олон, олон жилийн дараа Люсийг өндөр настай болсон хойно нь би түүнтэй уулзаж билээ. Түүнийг бидэнд зааж байсан тэрхүү олон жилийн өмнөх явдлыг бид дурсан ярив. Бид ангийнхаа хүүхэд нэг бүрийн тухай ярилцаж, одоо бүгдээрээ ямар ажил хийж байгаа талаар ярив. Түүний хайр халамж амьдралын турш дурсагдах болно.

Итгэлийн Тунхаг

Миний амьдралд тохиолдсон өөр нэгэн бурханлигаар нөлөөлөгдсөн багш бол манай гадасны Хүүхдийн хэсгийн гишүүн Ерма Боллвинкел байсан юм. Итгэлийн Тунхагийг сурах нь ямар чухал болохыг тэрээр бидэнд байнга сануулдаг байсан юм. Үнэнийг хэлэхэд, хэрэв бид итгэлийн тунхагийг цээжээр сайн цээжлээгүй л бол Хүүхдийн хэсгийг төгсөж чаддаггүй байсан юм. Энэ нь эрч хүчтэй хөвгүүдэд нилээд хэцүү зүйл байсан боловч бид хичээсээр амжилттай давдаг байлаа. Ингэсний үр дүнд би амьдралынхаа турш Итгэлийн Тунхагийг ямар ч үед цээжээр хэлж чаддаг болсон юм.

Олон жилийн турш Арванхоёр Төлөөлөгчийн гишүүн байх явцдаа би Зүүн Герман буюу бүхний сайн мэддэг Бүгд Найрамдах Герман Улсыг хариуцан ажилладаг байсан юм. Энэхүү томилолтод минь Итгэлийн Тунхагийн мэдлэг маань ихээхэн тусалсан. Энэ бүсийг хариуцсан хорин жилийн турш зочилсон гишүүн бүртээ Итгэлийн Тунхагийн 12-рт байдаг: “Хаад, ерөнхийлөгчид, удирдагчид, мөн шүүгчдэд захирагдаж хуулийг дуулгавартай дагаж,

хүндлэн дээдэлж, мөн дэмжих ёстой гэдэгт бид итгэдэг.”

Тухайн үед Төмөр Хана хэмээн нэрлэгддэг байсан хананы цаана хийдэг байсан бидний цуглаануудыг тэндхийн коммунист засгийн газар нь үргэлж хянадаг байлаа. 1980-аад оны эхээр бид засгийн газрын албан тушаалтнуудаас ариун сүм барих зөвшөөрөл, удалгүй тэндхийн эрэгтэй эмэгтэй залуусыг дэлхий даяар үйлчлэх болон бусдыг тэдний улсад ирж номлолд үйлчлэх зөвшөөрөл хүсэх үед тэд “Ахлагч Монсон, бид таныг хорин жил ажиглалаа, тэгээд та болон танай сүмд итгэж болно гэдгийг бид мэдсэн. Учир нь та бүхэн гишүүддээ тухайн газар нутгийнхаа хуулийг дуулгавартай дагахыг заадгыг бид мэднэ”. хэмээн хэлсэн юм.

Итгэлийн Тунхагийг сурах үнэ цэнийн талаар би дахин нэг жишээ хуваалцмаар байна. 45 жилийн өмнө би Солт Лейк хотод Шарман Хаммел гэгч хүнтэй хэвлэлийн бизнест хамтран ажилладаг байлаа. Нэгэн удаа би түүнийг ажлаас нь гэрлүү нь хүргэн өгөхдөө тэрээр хэрхэн сайн мэдээний тухай гэрчлэлийг олж авсан тухай асуусан юм.

Тэрээр “Том чи надаас энэ асуулыг асуусан нь их сонирхолтой юм, учир нь яг энэ долоо хоногт би эхнэр болон хүүхдүүдтэйгээ Мантайн Ариун Сүм орж мөнхийн лацлалт хийлгэх болно” гэв.

Тэрээр үргэлжлүүлэн, “Бид Зүүн эрэг хавьд амьдардаг байлаа. Би Сан Францискод шинээр хэвлэлийн компани байгуулж, дараа нь эхнэр хүүхдээ тийш нь явуулаа гэсэн зорилготойгоор Сан Франциско руу автобусаар явж байлаа. Нью Йоркоос Солт Лейк хот хүртэл ямар ч үйл явдалгүй аялал болж байлаа.

Харин Солт Лейк хотоос — Хүүхдийн Хэсгийн—нэгэн бяцхан охин автобусанд орж ирэн миний хажууд суулаа. Тэр Невадагийн Рено хотод амьдардаг авга эгчийндээ зочлохоор явж байлаа. Бид баруун тийшээ аялах үед, ‘Энэ долоо хоногт Мормончуудын Ням гарагийн Ангид зочлоорой’ гэх самбарыг би олж харлаа.

Тэгээд би бяцхан охинд хандан, “Миний бодож байгаагаар Ютад олон Мормончууд байдаг байхаа, тийм биз?” гэж асуув.

“Тэр ‘Тиймээ, ноёнтоон’ хэмээн хариулав.

“Тэгээд би түүнээс ‘Чи Мормон уу?’ гэж асуув.

“Тэр ахиад л ‘Тиймээ, ноёнтоон’ хэмээн хариулав.

“Мормончууд юунд итгэдэг юм бэ?” хэмээн Шарман Хаммел асуужээ. Нөгөөх бяцхан охин Итгэлийн Тунхагийн нэгдүгээрхийг цээжээр давтаад түүнийхээ тухай надад ярьж өгөв. Үргэлжүүлэн, тэрээр Итгэлийн Тунхагийн хоёрдугаархыг давтаад мөн л түүнийхээ тухай ярьж өгөв. Энэ мэтчилэн тэрээр гуравдахь, дөрөвдэх, тав дахь, зургаа дахь гэсээр бүх Итгэлийн Тунхагийн тухай надад ярьж өгөв. Бяцхан охин бүгдийг нь дарааллаар нь цээжээр мэддэг байв.

Шарман Хаммел: “Бид Ренод ирээд тэр бяцхан охиныг түүний нагацын гарт тэврүүлэх тэр үед би агуу ихээр гайхширч догдолсон байлаа” хэмээн хэлсэн юм.

Тэрээр үргэлжлүүлэн, “Сан Франциско хүрэх бүх замын турш ‘Энэ бяцхан охиныг сургаалиа ийм сайн мэдэхэд нь юу түүнийг ингэж ихээр нөлөөлөв өө?’ хэмээн бодсоор байв. Сан Францискод очоод миний хийсэн эхний зүйл нь утасны лавлагаас Есүс Христийн Хожмын

Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг хайсан явдал байв. Би Номлолын Ерөнхийлөгчтэй утсаар ярьснаар тэрээр миний байрлаж байсан газар уруу хоёр номлогчийг илгээсэн юм. Тэгээд удалгүй би Сүмийн гишүүн болж, миний эхнэр гишүүн болж, мөн манай бүх хүүхдүүд гишүүн болсон нь Хүүхдийн хэсгийн нэгэн охин Итгэлийн Тунхагийг мэддэг байснаас үүдсэн юм” гэж билээ.

Би Төлөөлөгч Паулын хэлсэн “Би сайн мэдээнээс ичихгүй, яагаад гэвэл тэр нь авралд хүргэх хүч мөн” хэмээх үгсийг бодлоо (Ром 1:16)

Яг гурван сарын өмнө Хаммелийн гэр бүлийнхэн өөрсдийн охин Марианны хуриманд оролцохоор Солт Лейк хотод ирсэн юм. Тэд миний албан өрөөгөөр зочлон бид гайхалтай цагийг өнгөрүүлэв. Бүх хүүхдүүд нь буюу зургаан охин, дөрвөн хүргэн хүү, мөн арван хоёр ач гучийнхаа хамт ирсэн байлаа. Тэр гэр бүл бүхлээрээ сүмд идэвхитэй байв. Бүх охид нь ариун сүмд орсон байв. Энэ гэр бүлийн гишүүдээр дамжин сайн мэдээний мэдлэг олж авсан хүмүүсийг тоолж баршгүй. Энэ бүхэн нь зөвхөн тэр бяцхан хүүхэд Итгэлийн Тунхагийг заалган, түүний үнэнийг, сай мэдээний гэрлийг хайгч нэгэнд тунхаглах ур чадвар, эр зоригтой байснаас үүдсэн юм.

“Үргэлж бэлэн бай”

Би Сургаал ба Гэрээний 88 дугаар хэсэгт байдаг “Мөн хаант улсын сургаалыг та нар бие биендээ заах болно хэмээх зарлигийг би та нарт өгч байна. Хичээнгүйлэн заагтун та нар, мөн миний ач ивээл та нартай байх болно” хэмээх Их Эзэний өгсөн сургаалд их дуртай.

Олон жилийн өмнө би өмнөд Калифорни уруу онгоцоор аялахаар

сууж байтал, хажуу талын хоосон сандал дээр нэгэн залуу эмэгтэй ирж суулаа. Тэрээр ном уншиж эхэллээ. Надаас өөр хүн ч тэгэх байх, би гарчигийг нь хальт харлаа:

Гайхамшигт бөгөөд Агуу Ажил гэж байв.

Би түүнд: “Өө, та чинь Мормон байх нээ” гэж хэлэв.

Тэрээр хариуд нь, “Өө, үгүй дээ. Та яагаад ингэж асуугаав?” гэлээ.

Би хариуд нь: “Ингэхэд та чинь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн нөлөө бүхий гишүүдийн бичсэн номыг уншиж байна шүү дээ” гэлээ.

Тэр эмэгтэй, “Энэ үнэн үү? Миний нэгэн найз надад үүнийг өгсөн юм, харин би үүний талаар их юм мэдэхгүй ээ. Гэсэн хэдий ч миний сониуч занг их хөдөлгөж байна” гэв.

Тэгээд би дотроо, “Би шулуухан байж Сүмийн талаар илүү зүйлийг түүнд хэлж өгөх хэрэгтэй юу?” хэмээн гайширангаа Төлөөлөгч Петрийн хэлсэн: “Та нарын доторх найдварын талаар асуух хүн бүрд хариу өгөхөд ямагт бэлэн бай” гэснийг бодлоо (1 Петр 3:15). Би одоо л гэрчлэлээ хуваалцах хэрэгтэй гэж шийдлээ.

Олон жилийн өмнө Агуу бөгөөд *Гайхамшигт Ажил* номыг хэвлэхэд нь ахлаг Ричардад туслах таатай боломж олдсон тухай би түүнд хэлэв. Би түүнд тэр гайхалтай хүний тухай ярьж өгөв. Мөн түүнчлэн түүний бэлтгэсэн тэр номыг уншаад үнэнийг бишэрсэн тэдгээр олон мянган хүмүүсийн тухай би түүнд ярьлаа.

Энэ мэтчилэн бүр Лос Анжелес хүртэл сүмийн холбогдолтой түүний чин сэтгэлийн үнэнийг хайсан ухаалаг асуултуудад хариулах нь надад таатай байлаа. Тэгээд би түүнээс хоёр эмэгтэй номлогч түүнтэй

утсаар ярьж болох эсэх, Сан Франциско дахь түүний амьдардаг харъяалалын салбарт очих эсэхийг асуулаа. Түүний хариулт нааштай байлаа.

Би гэрлүүгээ буцах замдаа Сан Франциско Гадасны Ерөнхийлөгч Ирвен Ж.Деррикд захиа бичин энэхүү эмэгтэгийн мэдээллийг дамжуулаа. Хэдхэн сарын дараа Ерөнхийлөгч Деррик утасдан “Ахлагч Монсон, таныг Лос Анжелес уруу нисэхэд хажууд тань суун Агуу бөгөөд *Гайхамшигт* номыг уншиж байх нь зүгээр л нэг тохиолдол биш юм гэж хэлсэн тэр ажлаасаа бууж явсан онгоцны үйлчлэгч залуу эмэгтэйн тухай би хэлэхээр утасдаж байна. Тэр эмэгтэй дөнгөж саяхан Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хамгийн шинэхэн гишүүн боллоо. Тэрээр таньтай ярьж талархалаа илэрхийлхийг хүсэж байна” хэмээн хэлэхэд миний баяр баясал ямар их байсныг та бүхэн төсөөлөх ч үгүй. Мэдээж би маш ихээр баярласан. Энэ бол гайхалтай утасны яриа байлаа.

Ерөнхийлөгч МакКейн Үлгэр Жишээ

Намайг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр дуудсан Ерөнхийлөгч Давид О.Маккей бол чадварлаг сайн багшийн нэг жишээ юм. Тэрээр мэдрэмж, хайрыг хослуулан заадаг байсан юм. Тэрээр заасан зүйлийнхээ хамгийн сайн жишээ болж чаддаг байсан. Түүний зүрх сэтгэл нь сайхан, мөн ихэд талархалтай хүн байсан юм. Мөн тэрээр Мастер багш болох Аврагч Есүс Христийн жишээгээр заадаг тийм нэгэн багш байсан юм.

Би Ерөнхий Эрх Мэдэлтэн болохоосоо олон жилийн өмнө зарим



Даалгавараа биелүүлчихээд иддэг Ням гарагийн оройн хоол маань үргэлж л илүүд гойд амттай санагддаг байж билээ.

зөвшөөрөгдсөн хэвлэлийг үзэхээр түүний албан тасалгаанд орохдоо түүний энэ чанарыг нь олж харсан юм. Яг тэр үед би ханан дээрх уран зургийг хараад түүнээс, “Ерөнхийлөгч Маккей, тэр маш сайхан зураг байна шүү. Энэ таны хүүхэд байхдаа амьдарч байсан Ютагийн Хантсвиллийн зураг мөн үү? хэмээн асуулаа.

Тэрээр арагш сандлаа налан суугаад, танил Давид О.Маккей царай гарган инээмсэглээд, “Наад зурагны чинь талаар би чамд хэлж өгье. Намрын нэгэн сайхан өдөр нэгэн эмэгтэй надтай уулзахаар ирэн жаазлан янзалж хананд хадахад бэлэн болсон энэ сайхан зургийг өгсөн юм. Тэр эмэгтэй, ‘Ерөнхийлөгч Маккей, Би таны өвөг дээдсийн байшингийн энэ зургийг зурахад зуны ихэнхийг зарцуулсан юм шүү’ гэж хэлэв. Тэрээр тухайн эмэгтэй бэлгийг хүлээн аваад түүнд баяр талархалаа илэрхийлсэн гэв.

“Монсон ах, юу гээч” гэж тэрээр үргэлжлүүлэн, “Тэр сайн эмэгтэй маань буруу байшин зурсан байлаа. Тэр хажуу талын байшинг зурсан байсан юм. Та буруу байшин зур-

чихжээ гэж хэлэх зүрх надад байсангүй” гэв.

Ерөнхийлөгч Маккейн үргэлжлүүлэн хэлсэн нэг зүйл нь бид бүгдийн сурах гол хичээл юм. Тэрээр хэлэхдээ, “Бодит байдал дээр миний хувьд тэр эмэгтэй зөв байшин зурсан, учир нь залуу хөвгүүн байхдаа би байшингийнхаа урд саравчин дахь орон дээр хэвтээд миний хардаг байсан зүйл бол түүний зурсан тэр байшин байсан юм. Тэгэхээр миний хувьд тэр эмэгтэй зөв байшинг зурсан!” гэв.

Бусдад үйлчлэх тухай

Амьдралд сурч болох зарим сайн хичээлүүд нь бидний эцэг эхийн амьдралаас урган гардаг. Миний өсөх насанд эцэг эхийн маань амьдрал ихээхэн үнэ цэнэтэй зүйлсийг сургасан юм. Тэдгээр хичээлүүдийн олонхи нь бусдад үйлчлэхтэй холбоотой байсан. Би хөвгүүн байх үеийнхээ олон дурсамжийг санадаг юм. Тэдний нэг нь ням гарагийн оройн хоолыг тэсэн ядан хүлээдэг байсан тэр үе юм. Удаан жигнэж болгосон үхрийн махны үнэр өрөөг дүүргэх тэр мөчид ширээгээ той-

рон хоолоо хүлээх хүүхдүүд бид өөрсдийгөө өлсөж үхэх нь л гэж бодож байдаг сан. Энэ зуур ээж маань, “Томми, бид хоолоо идэхээс өмнө миний бэлдэж тавьсан энэ тавагтай хоолыг доод гудамжны Хөгшин Бобд хүргэж өгөөд хурдан буцаад ир” гэж хэлдэг байв.

Эхэлж өөрсдөө идээд түүний тавагтай хоолыг дараа нь яагаад аваачиж өгч болдоггүйг би хэзээ ч ойлгодоггүй байсан юм. Гэвч би энэ талаар хэзээ ч асууж байгаагүй. Түүний гэр рүү гүйн очоод Бобын хөгширч туйлдсан алхаагаар хаалгандаа хүрч ирэхийг нь хүлээдэг байлаа. Тэгээд би түүнд тавагтай хоолыг өгөхөд тэрээр өмнөх Ням гарагийн хоолны толбогүй цэвэрхэн тавгийг эргүүлэн өгөхдөө миний үйлчилсний хөлс болгож арван центийн зоос хамт өгөхийг завддаг байлаа.

Миний хариулт үргэлж ижил байдаг: “Би мөнгийг авч болохгүй. Ээж маань намайг загнах болно” гэж хэлэхэд тэрээр үрчлээ суусан гараараа миний шаргал үсийг илбээд, “Хүү минь, чиний ээж маш гайхалтай хүн. Түүнд баярлалаа гэж хэлээрэй” гэдэг байв.

Энэ ажлаа хийж ирчихээд иддэг Ням гарагийн оройн хоол маань үргэлж л илүү амттай санагддаг



Өвөө маань халаасаа ухан түлхүүр гаргаж ирээд Хөгшин Бобд өглөө.

байсныг би санаж байна.

Миний өвөө, Томас Конди надад бас хүчирхэг хичээлийг зааж байсан юм. Бидний амьдралд сонирхолтой байдлаар орж ирсэн Хөгшин Боб мөн л үүнд холбоотой байв.

Бэлэврэн хоцорсон Хөгшин Бобын өрөө түрээслэн амьдарч байсан байшинг нураах үед тэрээр ная гаран настай байлаа. Өвөө бид гурав урд саравчин дээрх савлуур дээр сууж байх зуур түүнийг энэ зовлонгоо өвөөд хэлж байхыг би сонссон юм. Тэрээр ихэд шаналсан хоолойгоор өвөөд хэлэхдээ, “Ноён Конди, Би юу хийхээ мэдэхгүй байна. Надад гэр бүл гэж байхгүй тэгээд бас надад маш бага мөнгө байна” гэсэн юм. Өвөө хэрхэн хариулах бол гэж би гайхаж байлаа.

Өвөө удаанаар халаас уруугаа гараа шургуулан, удаан шаналгасны эцэст олон мөнгөн зоос гарган надад өгдөг байсан хуучин ширэн түрийвчээ гаргаж ирлээ. Харин энэ удаа өвөө тэндээс түлхүүр гаргаж ирэн Хөгшин Бобд өглөө.

Тэрээр зөөлнөөр, “Боб, энэ хажуу талын миний эзэмшдэг байшингийн түлхүүр. Үүнийг ав, тэгээд эд зүйлсээ нүүлгэж оруул. Хүссэн хугацаагаараа байж болно. Тэнд чи ямар ч түрээс төлөхгүй, хэн ч чамайг ахин хөөн гаргахгүй” гэж хэллээ.

Хөгшин Бобын нүдэнд нулимс

дүүрэн ирснээ хацрыг нь даган урсаар түүний урт цагаан сахал руу орон алга болж байлаа. Өвөөгийн маань нүд ч мөн нулимсаар дүүрсэн байв. Би тэр үед юм яриагүй ч өвөөгөө бахдан биширч байсан юм. Би түүний нэрийг хэлэхэд ч бахархдаг байв. Хэдийгээр би жоохон хөвгүүн байсан ч тэр хичээл миний амьдралд хүчирхэг нөлөө үзүүлсэн юм.

Эдгээр сургамжууд нь миний амьдралыг ихээр нөлөөлсөн тэдгээр хүмүүсийн надад заасан, тэднээс сурсан сургамжуудын зөвхөн

цөөн хэсэг нь юм.

Ахиад, би давтан хэлэхэд бид бүгд багш нар юм шүү. Бид зөвхөн үгсээрээ ч бус байгаа байдлаараа, хэрхэн амьдарч байгаагаараа бусдад заадаг юм гэдгийг бид байнга санаж байх хэрэгтэй.

Төгс жишээ

Бид бусдад заах үедээ төгс багш, бидний Аврагч Их Эзэн Есүс Христийн жишээг дагацгаая. Тэрээр мөрөө далайн эргийн элсэн дээр үлдээсэн ч гэсэн, Түүний заасан зарчмууд нь сонссон тэдгээр бүгдийн зүрх сэтгэлд, мөн амьдралд нь үлдсэн юм. Тэрээр тэр үеийн шавь нартаа ч, мөн бидэнд ч “Намайг дага” (Иохан 21:22) гэсэн нэгэн адил үгийг хэлсэн юм.

Гэтэлгэгч маань бидний хүн нэг бүрийг “Та бол Бурханаас илгээгдсэн багш” (Иохан 21:22) хэмээн хэлэхүйц тийм дуулгавартай сүнсийг агуулан бүгдээрээ урагшилцгаах болтугай хэмээн би залбирч байна. Есүс Христийн нэрээр, Амен. ■

